



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/05

Хөхбүрд

“Наранмандал энтерпрайзес” ХХК-ий уул уурхайн  
үйлдвэрлэлийн барилга, байгууламжийн  
зориулалттай нэгж талбарыг хувааж,  
зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1, 7.5, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Наранмандал энтерпрайзес” ХХК (5295858)-ий хүсэлтийг харгалзан Мандалхайрхан 1 дүгээр багийн нутагт орших 6408000793 нэгж талбарын дугаартай 7475898м2 газар, 6408000794 нэгж талбарын дугаартай 2821653 м2 талбай бүхий, нөөц газрын зориулалттай газрыг хавсралтын дагуу хувааж, зориулалтыг өөрчилсүгэй.

2.Газрыг зүй зохистой ашиглаж, гэрээг жил бүр дүгнүүлж байхыг “Наранмандал энтерпрайзес” ХХК-ний гүйцэтгэх захирал (К.Жерард)-д хариуцуулсугай.

3.“Наранмандал энтерпрайзес” ХХК-ний ашиглалтын газруудыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээ олгож, гэрээ байгуулахыг Газрын даамлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч (Э.Түвшинжаргал), Газар ашиглагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаад хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Н.Эрдэнэванчин) нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Гансүх)-д даалгасугай.



ДАРГА Т.БЯМБАДОРЖ

642501325



Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 1-ны өдрийн 1/03 дугаар захирамжийн хавсралт



НАРАНМАНДАЛ ЭНТЕРПРАЙЗЕС ХХК-ИЙН АШИГЛАЛТЫН ГАЗРЫН НЭГЖ ТАЛБАРЫГ ХУВААЖ, ЗОРИУЛАЛТ ӨӨРЧЛӨГДСӨН МЭДЭЭЛЭЛ

№	Газар ашиглагч хуулийн этгээдийн нэр	Хуучин үүссэн газрын				Шинээр үүсэх газрын	
		Газрын зориулалт	Эрх олгосон шийдвэрийн огноо дугаар	Нэгж талбарын дугаар	Талбайн хэмжээ /м2/	Талбайн хэмжээ /м2/	Газрын зориулалт
1	2	3	4	5	6	7	8
1	"Наранмандал энтерпрайзес" ХХК	2603: Нөөц газар	2025.10.07 А/117	640800793	7475898	6481936	2603: (Нөөц газар)
						26717	2604: (Уул уурхайн тэсэрч дэлбэрэх бодисын агуулах)
						740670	2601: (Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай)
						82560	2601: (Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай)
						129682	7401: (Аюултай хог хаягдалын төвлөрсөн байгууламж барих газар)
						14333	2117: (Шатахуун түгээх газар, агуулах)
2	"Наранмандал энтерпрайзес" ХХК	2603: Нөөц газар	2025.10.07 А/117	640800794	2821653	1403452	2603: (Нөөц газар)
						952672	2602: (Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж)
						406529	2601: (Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн талбай)
						59000	7401: (Аюултай хог хаягдалын төвлөрсөн байгууламж барих газар)

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_